

АХУЙН БОХИР УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ШУГАМ ХООЛОЙ УГСРАХ АЖЛЫН ДААЛГАВАР.

1. Хилийн Гашуунсухайт боомтын хэрэглээнд зориулагдаж угсрах цэвэрлэх байгууламж нь сүүлийн үеийн дэвшилтэд технологид суурилсан байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал бага байхаар тооцоолон төлөвлөгдсөн, боомтын хуучин цэвэрлэх байгууламжийн дэргэд тохиромжтой байршилд байрлуулах;
2. Шинээр угсрах цэвэрлэх байгууламж, түүний шугам хоолой нь газрын өндөржилтөөс хамаарч шаардлагатай бол бохир усны шугаман дээр өргөлтийн насос суурилуулах, мөн цэвэрлэсэн саарал усыг шингээх талбайтай байх;
3. Цэвэрлэх байгууламжийн цахилгаан хангамжийг боомтод одоо ашиглагдаж байгаа цэвэрлэх байгууламжийн тэжээлийн 0.4 кВ-ын цахилгааны самбараас кабель шугамаар холбогдохоор тооцох;
4. Шинээр суурилуулах цэвэрлэх байгууламжийн шугамыг одоо байгаа бохирын нэгдсэн шугамтай холбох бөгөөд холбох трассыг зөв сонгож тооцоолох /шугамын урт нь 20м -ээс 230м хэтрэхгүй байх/;
5. Цэвэрлэх байгууламж болон бохир усны шугамыг угсрахдаа боомтын бусад инженерийн шугам сүлжээтэй уялдуулсан байх, мөн газар шорооны ажлыг гүйцэтгэхдээ тухайн ашиглагч байгууллагатай зөвшөөрөлцөн тэдний хяналтын дор хийх;
6. Угсралтын ажлын технологийн үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг захиалагчийн хяналтаар тухай бүр шалгуулах, техникийн шаардлага хангасан гэж үзвэл эрх бүхий мэргэжлийн байгууллагаар туршилт, шахалтыг хийлгэх зөвшөөрлийг авч ил, далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг баталгаажуулах;
7. Ажлын талбайд машин механизм ажиллуулах үед орчны аюулгүй байдлыг ханган ажиллах ба хамгаалалтын хүрээ үүсгэж шаардлагатай бол явган зорчигчдод зориулсан түр гарц байгуулах;
8. Угсралтын ажлыг гүйцэтгэх явцад хилийн боомтын инженерийн шугам сүлжээг (цахилгаан, шилэн кабель, цэвэр бохир, дулаан гэх мэт) гэмтээхгүй байх, хэрэв хохирол учруулбал шугамын алдагдал болон бусад зардлыг гүйцэтгэгч бүрэн хариуцна. Түүнчлэн ногоон байгууламж, үерийн байгууламж зам талбайг эвдэхээр бол нөхөн сэргээх зардлыг төсөвтөө тусган хийж гүйцэтгэх;
9. Цэвэрлэх байгууламж, тоног төхөөрөмж, шугам хоолойг угсарч дууссаны дараа аймаг орон нутгийн ус хангамж, дулааны шугам сүлжээ хариуцсан мэргэжлийн байгууллагуудын биет төлөөлөгчийн зөвшөөрлөөр шалган, угаалга хийсний дараа байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх;
10. Цэвэрлэх байгууламжийн технологийн схем, зураг, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны зааврыг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгч, цэвэрлэх байгууламжийн ажиллагааны зарчим, техникийн үзүүлэлт, засвар үйлчилгээний талаар сургалт зохион байгуулах;